



“Глоб Интернэшнл”  
төрийн бус байгууллага



АНУ-ын Элчин сайдын яам



Нээлттэй Нийгэм Форум

# Хэвлэлийн эрх чөлөөний Тайлан

2009 он



## Гарчиг

### 1. Өмнөтгөл

### 2. Хэвлэлийн эрх чөлөө 2009 онд

- Сэтгүүлчдийг айлган сүрдүүлэх нь
- Цензур буюу цагдан хяналт
- Мэдээллийн эрх чөлөө
- Цагдаагийн үйлдэл
- Нууц эх сурвалжаа хамгаалах нь
- Хэвлэл мэдээлэл ба Ерөнхийлөгчийн сонгууль
- Нэр төр гутаахтай холбоотой хуулийг ашиглаж буй нь

### 3. Хэвлэл мэдээллийн эрх зүйн хүрээ

*Энэ тайланг бэлтгэхэд дэмжлэг үзүүлсэн ивээн тэтгэгчдэд  
гүн талархал илэрхийлье.*

## Өмнөтгөл

Бид та бүхэнд хэвлэлийн эрх чөлөөний 2009 оны тайланг толилуулж байгаадаа таатай байна. Энэ боломжийг ашиглан энэ тайланг бэлтгэхэд гүн туслалцаа үзүүлсэн Нээлттэй нийгэм форум, ННХ-гийн Хэвлэл мэдээллийн бүсийн хөтөлбөр, Улаанбаатар хот дахь АНУ-ын Элчин сайдын яаманд талархал илэрхийлье.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, ялангуяа хэвлэлийн эрх чөлөө нь ардчилсан нийгмийн салшгүй хэсэг юм. Чөлөөт, хараат бус хэвлэл мэдээлэл бол улс төрч, эрх баригчдаас ард түмэнд өгч буй бэлэг биш. Хэвлэлийн эрх чөлөө, хараат бус хэвлэл бол ардчилсан нийгэмд амьдарч буй хүний суурь эрхийн нэг юм.

Төрөөс хараат бус хэвлэл мэдээллийн улс төр, эдийн засаг, эрх зүйн таатай орчинг хэрхэн бүрдүүлж буй нь түүний иргэндээ үйлчлэх үүргийн биелэлтийн хэмжүүр юм. Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээлэл, сэтгүүлчид төр, түүний эрх баригчдад бус олон түмэнд үйлчилж, нийгмийн хоточ нохой байж, эрх мэдлийг хянах үүрэг гүйцэтгэдэг.

2009 онд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах чиглэлээр эрх зүйн нааштай өөрчлөлт гарсангүй. Хэвлэл мэдээллийн эрх зүйн салбарт гарсан нэг өөрчлөлт нь Зар сурталчилгааны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт юм. Үүгээр Монголд хэвлэл мэдээллийн хэрэгслээр шар айраг, дарс сурталчлахыг зөвшөөрсөн нь хууль тогтоогчдын бодлоор эдийн засгийн хямралын үед ХМХ-ийг эдийн засгийн хувьд дэмжиж байгаа бус харин ч энэ шийдвэрийг гаргагчдын өөрсдийн бизнесийг дэмжсэн алхам болсон юм.

Монгол Улсад хэвлэлийн эрх чөлөөг хамгаалсан зарим нааштай хууль тогтоомж байгаа хэдий ч амьдрал дээр хэвлэл мэдээллийн эрх чөлөө, сэтгүүлчдийн мэргэжлийн эрх зөрчигдсөөр байна. Сэтгүүлчийн мэргэжлийн эрх ийнхүү зөрчигдөх нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлаж, сэтгүүлчид үнэн мэдээлэл түгээж чадахгүйд хүрч, ардчилал, нийгмийн эрх ашигт бодитой хор хохирол учруулж буй юм. Манайд цагдан хяналт (цензур)-ыг хуулиар хориглосон ч ил болон далд хэлбэрээр байсаар байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоож, сэтгүүлчдийг өөртөө үйлчлэхийг шаардах нь ардчиллын мөн чанар, хэм хэмжээ, зарчмаас гадуур үл тэвчиж болох үйлдэл билээ.

Улс төрч, албан тушаалтан, албан хаагчид Эрүүгийн хууль, Иргэний хуулийн заалтуудыг цензур болгон ашиглах нь түгээмэл байна. Монголын шүүх нэр төр, гүтгэлэгтэй холбоотой хэргийг шийдвэрлэхдээ олон нийтийн үнэн мэдээлэлтэй байх хууль ёсны эрх ашгийг нь авч үзэлгүй өрөөсгөл хандаж байгаа нь шүүхийн шударга, хараат бус байдалд эргэлзээ төрүүлж байна. Эрх баригчид өөрийн эрх мэдэл, албан тушаалыг ашиглан шударга шүүмжлэлийг няцаах, өөрсдийн буруутай үйлдлийг ард иргэдээс нуун дарагдуулахын тулд үнэн мэдээллийг саармагжуулах хүсэлтэй байна.

Монголын сэтгүүлчид өнөө хэр төрийн байгууллага, албан тушаалтан, албан хаагчдаас мэдээлэл олж авч чадахгүй, төрийн байгууллагын бичиг

баримтыг олж үзэх боломжгүй байгаа нь төрийн байгууллагын олон нийтэд ил тод, нээлттэй байх ёстой ардчилсан зарчим алдагдаж, иргэдийн үнэн мэдээлэл олж авах эрх хөсөрдөхөд хүргэж байна. Энгийн мэдээлэл олж авах төдийд эрх нь зөрчигдөж буй сэтгүүлчид далд нуугдмал буй мэдээлэл, баримт мэдээг эрэн сурвалжилж олон түмэнд мэдээлэхэд туйлын хүндрэлтэй байгааг илтгэж байна.

Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл нийтэд ил тод бус байгаа нь олон ургальч үзлийг хөхиүлэн дэмжих бус, харин тэдгээрийн далд эздийн үзэл бодол, нэг талыг барьж туйлширсан мэдээллээ олон түмэнд тулган нийгмийг төөрөгдүүлэн будлихад хүргэж байна. Монголын олон нийт хэн нь үнэн ярьж байгааг ойлгохоо байж, хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдэд итгэл алдрах нь нийгмийн шударга ёсыг уландаа гишгиж буй хэрэг юм.

Сэтгүүлчид янз бүрийн дарамт шахалт дор эх сурвалжаа илчлэх нь мэдээлэгчдийн аюулгүй байдалд ноцтой хор учруулах төдийгүй хэвлэл мэдээлэл ард иргэдийн өмнө хүлээсэн хяналтын үүргээ хөсөрдүүлэхэд хүргэнэ. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн ач холбогдол, үнэ цэнэ алга болбол нийгэм хэзээ ч цэвэршиж, ариусахгүй.

Үнэнийг хэлэх гэсэн, хэлснийх нь төлөө сэтгүүлчдийг дайрч давшлах, далайлган сүрдүүлэх, айлган заналхийлэх, өмч хөрөнгө, бие эрхтэнд халдах нь хэрхэвч байж болохгүй ноцтой үйлдэл, гэмт хэрэг юм. Монголын цагдаа, шүүх буруутныг илрүүлэн үнэн мөнийг тогтоож, хариуцлага хүлээлгэх үүргээ зохих ёсоор биелүүлж чадахгүй байгаа нь харамсалтай.

Энэ тайлан нь Монголын сэтгүүлчид мэргэжлийн эрхээ хэрхэн эдэлж буй, тэдний олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа шударгаар биелүүлэх боломж нь аль хэр байгааг баримтад тулгуурлан монголын хэвлэлийн эрх чөлөөний өнөөгийн дүр төрхийг харуулах зорилготой юм.

Өмнөтгөлөөс гадна энэ тайлан хоёр бүлэгтэй.

Эхний бүлэгт “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагаас 2009 онд хэвлэлийн эрх чөлөөний байдалд онцолж буй зүйлийг оруулсан болно. Хоёрдугаарт бүлэгт иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулж буй болон хязгаарлаж буй үндэсний хууль тогтоомжийн тухай мэдээлэл багтсан.

**НЭГ. ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ 2009 ОНД**

Хэвлэлийн хүрээлэнгийн “Монголын хэвлэл мэдээллийн өнөөгийн байдал” мониторингийн судалгаагаар 2009 онд Монголд 383 хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 3840 хүн ажиллаж байв. Үүнээс сэтгүүлч, бусад бүтээлч ажилтан 1709 байжээ. Хэвлэл мэдээллийн нийт хэрэгслийн 34 хувь нь хөдөө орон нутагт ажиллаж байна. Монголд гадаад хэлээр зургаан сонин, үндэстний цөөнх болох казах хэлээр нэг сонин гарч байна.

Сүүлийн хоёр жилд онлайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо хоёроос гурван дахин нэмэгдсэн байна. 2009 онд 10 цахим сонин, таван цахим сэтгүүл бүртгэгджээ. Өдөр тутмын гурван сониныг цахим хуудаснаас уншиж, зургаан радио, 11 телевизийн нэвтрүүлгийг интернэтээр сонсож, үзэж болно. [www.sopin.mn](http://www.sopin.mn) цахим хуудаснаас 24 сонин уншиж болно.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага ННФ, ННХ-гийн Хэвлэл мэдээллийн бүсийн хөтөлбөрийн дэмжлэгээр 2005 оны 10-р сараас сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчилд мониторинг хийж байгаа билээ.

2009 оны эхний хагас жилд хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн эсрэг 20 зөрчил бүртгэгджээ. 2009 онд сэтгүүлчийн бие махбодь, ажлын багаж хэрэгсэлд халдсан тохиолдол бүртгэгдээгүй байна. Гэхдээ сэтгүүлчдийг сүрдүүлсэн, дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, гэр бүлийн хүнийг дарамталсан тохиолдол 13 бүртгэгджээ.

Сүүлийн хагас жилд зөрчил бүртгэгдээгүй нь байдал сайжирсандаа бус, харин мэргэжлийн эрхийн зөрчлийнхөө тухай мэдээлдэг сэтгүүлчдийн тоо буурсантай холбоотой юм. Учир нь, зөрчлийнхөө тухай олон нийтэд мэдээлсний дараа сэтгүүлчдэд үзүүлэх дарамт шахалт, сүрдүүлэг заналхийлэл нэмэгддэг байна. Энэ нь “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагаас 2009 оны арван нэг, арван хоёрдугаар сард хот, хөдөөгийн 215 сэтгүүлчийг хамруулсан судалгааны үр дүнгээр нотлогдож байна. Судалгаанд хамрагдагчдын 67.5 % нь эмэгтэй, 32.5% нь эрэгтэй сэтгүүлч байв. Тэдний 68.8% нь нийслэлд, 31.2% нь хөдөөгийн ХМХ-д ажилладаг ажээ.

Сэтгүүлчдийн 53.9% нь сонин хэвлэлд, 45.6% нь өргөн нэвтрүүлгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ажилладаг, 0.5% нь чөлөөт сэтгүүлч байв.

Дээр дурдсан судалгаа, мониторингийн дүнг үндэслэн “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага 2009 оны хэвлэл мэдээллийн эрх чөлөөний байдалд дараахь зүйлийг онцолж байна.

**1. Сэтгүүлчдийг айлган сүрдүүлэх нь**

Монголд Эрүүгийн хуулиар сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад учруулахыг гэмт гэрэг гэж үзсэн боловч энэ зүйл заалт үйлчилдэггүй.

Судалгаанд хамрагдсан зургаан сэтгүүлчийн нэг нь шүүмжлэлт материалаас болж, нэр төр гутаасан гэх гомдолтой тулгарчээ. Гомдол гаргасан хүмүүсийн дийлэнх нь сэтгүүлчийг ямар нэг байдлаар сүрдүүлсэн, заналхийлсэн, дарамталсан байна. Тэдний 81 хувь нь эрх мэдэлтэн, албан тушаалтан ажээ.

Зодно, ална, гэр бүлийн хүмүүст чинь халдана гэх мэт ноцтой сүрдүүлэг, заналхийлэлд сэтгүүлчдийн 20 шахам хувь өртсөн, мөн сэтгүүлчийн эрүүл мэндэд халдсан таван тохиолдол байгаа нь Монголд сэтгүүлчийн хөдөлмөр амаргүй болж буйг харуулж байна.

Судалгаанд хамрагдагчдын 60.4 хувь нь буюу 130 сэтгүүлч нэр төр гутаасан гэх асуудлаар ямар нэг сүрдүүлэг, дарамтад өртсөн байна. Үүнээс 50.8 хувь нь сүрдүүлэг, 40 хувь нь дарамтад өртсөн бол 23 хувийнх нь эсрэг нэр төр гутаахтай холбоотой хэрэгт холбогдсон байна.

Сүрдүүлгийн агуулгыг авч үзвэл, 42.3 хувийг шүүхэд өгнө, 33.1 хувийг ажлаас чинь халуулна, 7.7 хувийг шоронд суулгана, 6.9 хувийг ална, 5.4 хувийг зодно, 5.4 хувийн гэр бүлийн гишүүнд халдана гэж сүрдүүлж, заналхийлсэн байна.

Сэтгүүлчдэд учруулсан дарамтын хэлбэрийг авч үзэхэд, 70.8 хувийг утсаар, 33.1 хувьтай биеэр уулзаж, 16.1 хувийг албан тасалгаандаа ирэхийг шаардсан бол 3.8 хувийн бие махбодид хохирол учруулжээ.

Сэтгүүлчдийн 77 хувьд материал нь нийтлэгдэж, нэвтэрсний дараа, 14 хувь нь мэдээлэл цуглуулах явцад, 9 хувь нь материалаа боловсруулж байх үедээ сүрдүүлэг, заналхийлэлтэй тулгарсан байна.

Сэтгүүлчдийн эсрэг гомдол мэдүүлэгчдийн 69.2 хувь нь эрх баригчид, 21.4 хувь бизнесийнхэн, 9.4 хувь нь олон улсын байгууллага, одод, төрийн бус байгууллага байжээ.

## **2. Цензур буюу цагдан хяналт**

Монголд 1998 оны Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар төр, түүний байгууллага ОНМХ өмчлөхийг, мөн цензурыг хориглосон боловч амьдрал дээр байдал өөр байгаа юм.

Монголд хувийн хэвшлийн ХМХ давамгайлдаг. Гэхдээ Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаагаар нийт сонины 33 хувь, сэтгүүлийн 42 хувь, телевизийн 10 хувь, радиогийн 46 хувьд төрийн хяналт хэвээр байна.

Монголд бүх төрлийн цензур оршсоор байна. Хуулиар бол төрийн шууд цензур үгүй гэх боловч энэ нь төр, улс төрийн шууд цензур хэвлэл мэдээллийн өмчлөл, удирдлагаар дамжин ирдэг. Иймээс манайд редакцийн цензур туйлын хүчтэй байгаа нь яах аргагүй редакцийн хараат бус байдалд нөлөөлдөг.

### **Редакцийн цензур**

Сэтгүүлчдийн 66 хувь редакцийн цензур байдаг гэжээ. Энэ нь тэдний бичсэн материалын агуулгыг хянах ( 57.7%), зар сурталчилгаа олгогчдын тухай шүүмжлэлт материал нийтлэх, нэвтрүүлэхийг хориглох (42.9%), материалыг нийтэлж, нэвтрүүлэхээс татгалзах (38.7%), материалын зарим хэсгийг хасахыг шаардах (28.9%), сэтгүүлчдийн өөрийн олж ирсэн материалыг хэвлэдэггүй (22.5%), шийтгэж, цалин хасах (7.7%) хэлбэрээр илэрдэг гэсэн байна.

### **Өөрийн цензур**

Сэтгүүлчдийн дунд өөрийн цензур өндөр байна. Судалгаанд хамрагдсан сэтгүүлчийн бараг тал хувь буюу 48.8 хувь өөрийгөө цагдан хянадаг гэжээ. Тэднээс яагаад өөрийгөө цагдан хянадаг болохыг тодруулахад тавиас дээш хувь нь сүрдүүлэгт өртөх, доромжлуулахаас, тал шахам хувь нь шүүхэд дуудагдахаас, гурван сэтгүүлчийн нэг нь ажлаас халагдахаас айдаг байна. Мөн сэтгүүлчид шоронд орохоос, зодуулахаас, гэр бүлийн хүнийг дарамтлахаас айдаг ба цөөн хувь нь цалингаа хасуулахаас айж, өөрийгөө цагддаг байна.



Би “Өглөөний сонин”-ы 2008 оны есдүгээр сарын 11 –ний өдрийн №175 дугаарт “Цагдаагийн дэд хурандаа 20 сая төгрөгийн залилан хийжээ” гэсэн гарчигтай нийтлэл бичсэн юм.

Дээрх нийтлэлийг УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах албаны дэд дарга Ц.Батболдоос авсан мэдээлэл дээр тулгуурлан бичсэн. Миний нийтлэлд дурдагдсан Эргүүл тусгай хамгаалалтын газрын дэд дарга, цагдаагийн дэд хурандаа Н.Баярмагнай нь тухайн үед залилангийн хэргээр тус албанд шалгагдаж байсан билээ. Тухайн үед

“Зууны мэдээ”, “Ардчилал”, “Ардын эрх” сонинд ч энэ тухай нийтлэл гарсан юм. Гэсэн хэдий ч цагдаагийн дэд хурандаа Н.Баярмагнай манай сониныг мэдээллийг анх түгээсний хувьд шүүхэд өгсөн. Тэрээр нэр төрд нь халдсан хэмээн сард 200 ам.доллар ч хүрэхгүй цалинтай сэтгүүлч надаас 10 сая төгрөг нэхэмжилсэн юм.

Ингээд Баянзүрх дүүргийн шүүх хурал “Өглөөний сонин”-ыг цагдаагийн дэд хурандаагийн нэр төрд халдсан буруутай гэж үзсэн. Шүүх манай сонинд хоёр сая төгрөгийн торгууль тавьж, сониноороо дамжуулан нэр төрийг нь сэргээх шийдвэр гаргасан. Нийслэлийн Давж заалдах шатны шүүх мөн л “Өглөөний сонин”-ыг буруутай гэж үзсэн бөгөөд анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, торгуулийн хэмжээг нэг сая төгрөг болгон бууруулав. Нийслэлийн шүүхийн энэ шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй учир миний бие Улсын Дээд шүүхэд хандсан билээ.

Цагдаагийн дэд хурандаа Н.Баярмагнайд холбогдох эрүүгийн хэргийг 2008 оны 12 дугаар сард Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор Ц.Насанбат хэрэгсэхгүй болгон хаасан байдаг. Гэхдээ тэр үед цагдаагийн дэд хурандаа Н.Баярмагнайд холбогдох эрүүгийн хэрэг дахин сэргээгдсэн байлаа. Харамсалтай нь, Улсын Дээд шүүх үүнийг анхаарч үзэлгүйгээр Нийслэлийн Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр нь үлдээсэн юм.

Намайг дээрх нийтлэлийг бичсэний дараа түүний болон гэр бүлийнх нь хүмүүсийн залилангийн хэргийн золиос болсон олон хүн надад хандсан.

Албан тушаалтантай холбогдсон эрүүгийн хэргийн тухай шударга үнэнийг нийтэд хэлсэнийхээ төлөө шүүхийн өмнө буруутан болсондоо би үнэхээр харамсч байна.

**“Өглөөний сонин”-ы Эрэн сурвалжлах, шуурхай мэдээллийн албаны дарга Х.Намуун-Уянга**

### 3. Мэдээллийн эрх чөлөө

Төрийн байгууллагаас мэдээлэл авах эрх туйлын хязгаарлагдмал. Сэтгүүлчдэд мэдээлэл өгөхөөс татгалзах нь өдөр бүр тулгардаг бэрхшээл юм. Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, мөн өнөөдөр үйлчилж буй хуулийн бараг бүх хуулийн нууцын зүйл заалтаар Монголд мэдээллийн эрх чөлөөг хязгаарладаг. Өнөөдөр Монгол Улсад үйлчилж буй 360 гаруй хуулиас 33 хувьд л мэдээлэл нээлттэй байх зүйл заалт байдаг. Гэхдээ эдгээр зүйл заалт нь тунхаглалын чанартай, нарийвчилсан зохицуулалтгүй учир хэрэглэхэд хэцүү.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын мониторингийн судалгаагаар сэтгүүлчдийн эрхийн зөрчлийн гурван хэргийн нэг нь төрийн байгууллага мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдол байна.

### 4. Цагдаагийн үйлдэл

2009 онд цагдаагийн газраас хоёр бичиг баримт боловсруулж, нийслэл хотод үйл ажиллагаа явуулдаг телевизүүдэд хүргүүлжээ.

Эхнийх нь 2009 оны 5-р сард нийслэлийн цагдаагийн Олон нийтийн Харилцааны Хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Ч.Ганболд нийслэлд үйл ажиллагаа явуулдаг телевизүүдэд хандан илгээсэн захидал юм. Энэ захидалд “ТВ-чат нэвтрүүлгээр Монгол Улсын хууль тогтоомжийг илт зөрчсөн, бусдыг гэмт хэрэг үйлдэхэд өдөөсөн нийтээр дагаж мөрдвөл зохих хэм хэмжээг үл ойшоосон зар сурталчилгааг нилээдгүй явуулах” болсон тухай дурдаад “хууль зөрчсөн аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх нь танай байгууллагад хуулиар даалгасан үүрэг гэдгийг сайтар ухамсарлаж, хууль тогтоомжийн заалтыг баримталж, хэрэгжүүлж ажиллах шаардлагатай”-г сануулсан байна. Эцэст нь, захидлын хариуг 2009 оны 5-р сарын 20-ны дотор ирүүлэх, мөн хууль зөрчсөн аливаа үйл ажиллагаа давтагдвал зохих хариуцлага хүлээлгэх учиртай” хэмээн анхааруулжээ.

Хоёр дахь бичиг баримт нь Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвийн дарга, цагдаагийн хурандаа Т.Сайнжаргалын Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг телевизүүдтэй хийхээр хүргүүлсэн Хамтран ажиллах гэрээ юм. Энэ гэрээгээр гэрээний талууд “нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед нийгмийн хэв журам сахиулах цагдаагийн байгууллагын шуурхай ажиллагааг сурвалжлах, цагдаагийн байгууллагаас шаардлагатай мэдээллээр хангах, сурвалжлага хийх нөхцөл боломжоор хангах үүрэгтэй” байна. ЦЕГ энэ гэрээнд гарын үсэг зурсан “гэрээт телевизийн болон голомтод ажиллаж байгаа сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хариуцах” ажээ. Гэрээгээр гэрээт телевизэд дараахь зургаан зүйлийн үүрэг ногдуулсан байна. Үүнд:

- Мэдээллийг үнэн зөв, бодитой, түргэн шуурхай дамжуулах
- Жагсаал цуглааны үеэр нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болгохуйц ухуулга сурталчилгаа, буруу ташаа мэдээлэл дамжуулахгүй байх
- Мэдээллийг тэнцвэртэй хүргэх
- Хувь хүн, байгууллага, төрийн нууцад хамаарах асуудлаар мэдээлэл цацахгүй байх
- Ажиллагааны явцад төв штабтай байнга холбогдож, цаг үеийн мэдээлэл авч ажиллах
- Жагсаал цуглааны үеэр нийтийг хамарсан эмх замбараагүй байдал



үүсвэл түүнийг тараах, намжаах зорилгоор цагдаагийн байгууллагатай хамтран ухуулга сурталчилгаа хийх

Гэрээний Хариуцлага хэмээх 4-р зүйлээр талууд “үүргээ биелүүлээгүй буюу

зохиx ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа хуульд заасан хариуцлага хүлээж, гэм хор арилгах үүрэг хүлээнэ”.

Нэг жилийн хугацаатай энэ гэрээг телевизийн дийлэнх суваг хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурсан байна.

Энэ гэрээ нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл үнэн байх, ухуулга сурталчилгаа хийх үүрэг ногдуулсан, зөвхөн гэрээт телевиз, тэдгээрийн сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах, цагдаагийн байгууллагын шуурхай ажиллагааг сурвалжлах зэрэг хэд хэдэн ноцтой заалт агуулснаар хэвлэл мэдээллийн эрхэд халдсан гэж үзэж болно. Нөгөөтэйгүүр нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үеэр зөвхөн цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах ёстой гэдэг нь угаасаа энэ гэрээний агуулга нь цензурын шинжтэй болохыг харуулж байгаа юм. Хараат бус хэвлэл мэдээллийн байгууллага нь ухуулга сурталчилгаа хийх үүрэггүй бөгөөд нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үеэр цагдаагийн газрын үйл ажиллагааг ч шүүмжлэх эрхтэй. Түүнчлэн гэрээнд үнэн мэдээлэл, буруу ташаа мэдээлэл гэх зэрэг нэр томъёог хэрэглэсэн боловч аливаа тодорхойлолт байхгүй, хуулийн тодорхой зүйл заалтыг дурдаагүй байгаа нь ХМХ-ийг айлгах, цензур тавих шинжтэй болсныг бид шүүмжилж байгаа юм.

#### **5. Нууц эх сурвалжаа хамгаалах нь**

Монгол Улсад сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах хууль байхгүй. Судалгаанд хамрагдсан сэтгүүлчийн 36.9%-ийг эх сурвалжаа илчлэхийг шаардсан байна. Судалгаанд хамрагдсан 29 сэтгүүлчийг цагдаа, тагнуулаас 26 хэрэгт холбогдуулан дуудсан бол гурван хэрэгт сэтгүүлч гэрчээр дуудагджээ.

#### **6. Хэвлэл мэдээлэл ба Ерөнхийлөгчийн сонгууль**

2009 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа 2009 оны 4-р сарын 6-ны өдрөөс эхэлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн санал хураалтыг 2009 оны 5 -р сарын 24-ний өдөр явуулсан юм. Ерөнхийлөгчийн 2009 оны сонгуульд УИХ-д суудал бүхий Монгол Ардын Хувьсгалт Нам /МАХН/, Ардчилсан нам /АН/-аас нэг нэг нэр дэвшигч оролцож, УИХ-д суудал бүхий “Иргэний Зориг” нам, Ногоон нам АН-аас нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг дэмжихээ илэрхийлж, сонгуульд бие даан нэр дэвшүүлээгүй юм.

Сонгууль бол тухайн орны хэвлэл мэдээллийн хараат бус байдал, эрх чөлөө, олон ургальч байдлын шалгуур юм. Харамсалтай нь Ерөнхийлөгчийн 2009 оны сонгууль монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тэнд ажиллаж буй сэтгүүлчид улс төрөөс хэтэрхий хараат, сонгогчдод бус мөнгөнд үйлчилдгийг манай байгууллага, Хэвлэлийн хүрээлэнгээс хийсэн мониторингийн дүн нотолсон билээ. Үүнд нөлөөлж буй олон хүчин байдаг. Тухайлбал, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль нь ХМХ-ийг төлбөртэй сурталчилгаа хийх эрхийг хуульчилснаас бус улс төрийн нам, дэвшигчдийг шударгаар шүүмжлэх зэрэг боломж олгохгүй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн “Сонгууль бэлтгэн явуулах ажлын ил тод байдал” хэмээх 6 дугаар зүйлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд дараахь хоёр үүрэг ногдуулжээ .

1. Хэвлэл, мэдээллийн байгууллага сонгууль бэлтгэн явуулах ажлын явц, сонгуулийн дүнг олон нийтэд шуурхай мэдээлэх үүрэгтэй.

2. Төв, орон нутгийн сонин хэвлэл, мэдээллийн бусад байгууллагын нийтэлсэн мэдээлэл үнэн зөв байвал зохино.

Хуулийн 27-гийн 4 дэх хэсэгт “Нэр дэвшигчийг гүтгэх, доромжлох, нэр төрийг нь гутаах, түүний хувийн болон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно” гэсэн бөгөөд зөрчсөн тохиолдолд 800 000 төгрөгөөр торгоно.

2006 оны Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 14 зүйлээр сонгуулийн үеэр Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ) дэргэдээ хараат бус Хэвлэл мэдээллийн орон тооны бус зөвлөл байгуулах үүрэг ногдуулж, зөвлөл нь хэвлэл, мэдээллийн мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөл болон сонгуульд оролцож буй нам, эвслийн тэгш төлөөллөөс бүрдсэн байх тухай заажээ. Хуульд зааснаар Хэвлэл мэдээллийн зөвлөл нь нам, эвсэл, нэр дэвшигчийн хэвлэл мэдээллийн сурталчилгааны тэнцвэрт байдалд хяналт тавих бөгөөд энэ асуудлаар нам, эвсэл, нэр дэвшигч, хуулийн этгээд, иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан үзэж, санал дүгнэлт гаргаж Хороонд танилцуулах үүрэгтэй. Хэвлэл мэдээллийн зөвлөлд хяналт тавих техник, санхүүжилтийн нөөц байхгүй.

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ажиллах журмыг 2009 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан. Дарга нь заавал хэвлэл мэдээллийн мэргэжлийн байгууллагын төлөөлөл байх ёстой энэ зөвлөл нь сонгуулийн дүн албан ёсоор гарсан өдрөөс татан буугдана. Ерөнхийлөгчийн 2009 оны сонгуулийн үеэр Улаанбаатарт байрладаг телевизүүд сонгуулийн хууль зөрчсөн тухай хэд хэдэн гомдол ирсэн боловч огт шийдвэрлэгдээгүй.

СЕХ-ноос баталсан хоёр дахь журам нь Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан сонгуулийн үйл ажиллагааг сурвалжлах журам юм. Журамд 2009 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 16 тоот тогтоолоор нэмэлт оруулсан. Энэ журмын 2.4 дэх хэсэгт зааснаар сэтгүүлч уг журмыг зөрчсөн бол “...сонгуулийн хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга санал хураах байрнаас гаргах эрхтэй”

ХМХ-д хуулиар ногдуулсан үүрэг хэдий ч Ерөнхийлөгчийн сонгуулийн хэвлэл мэдээллийн сурталчилгаа тэнцвэртэй, шударга байсангүй. Нэр дэвшигчдийн тухай мэдээлэлд хэт нэг талыг барьсан, туйлширсан, өрөөсгөл байдал давамгайлсан байлаа. Сурталчилгааны дийлэнх хувь МАХН-ын нэр дэвшигч, тухайн үеийн Ерөнхийлөгч Н.Энхбаярт ногдсон билээ.

Телевизүүдийн мэдээний хөтөлбөр хүртэл сонгуулийн сурталчилгаа болон хувирч, нийт мэдээллийн бараг тэн хагас нь төлбөрт материалын шинж агуулж, сэтгүүлчдийг нэр дэвшигчдийн пи-ар ажилтан болгосон нь харамсалтай байлаа. Жишээ нь, манай мониторингид хамрагдсан телевизүүд нэр дэвшигчдийн тухай ихэнхдээ шууд бус мэдээлэл (82.1%) дамжуулжээ. Өөрөөр хэлбэл, телевизүүд нэр дэвшигчдийн тухай хэн нэгэн хоёрдогч, гуравдагч этгээд өөрсдөөс нь илүү ярьсан бөгөөд ХМХ-ийн сурталчилгаа хоёр нэр дэвшигчийн тухай хар пи-арын материалаар дүүрэн байсан юм.

Ер нь Монголд аливаа сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн эсрэг нэр төр гутаасан гэх гомдол, шүүхийн хэргийн тоо нэмэгддэг.

Монголын хуулиар сэтгүүлчид төлбөрт материалын өмнө ч хариуцлага хүлээдэг.

## **7. Нэр төр гутаахтай холбоотой хуулийг ашиглаж буй нь**

Олон улс оронд хувь хүний нэр төрийг хамгаалах нь иргэд хоорондын хэрэг гэж үздэг. Олон улсын хэм хэмжээ, эрх зүйгээр “Гүтгэлгийг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэх нь хүний нэр төрийг хамгаалахад онцын шаардлагагүй байдаг бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарладаг учраас хүлээн зөвшөөрөх боломжгүй” гэж үздэг. Олон улс оронд эрүүгийн хуулийн ийм заалтыг эрх мэдэлтэй албан тушаалтнууд хүмүүсийн шүүмжлэлийг хорьж хязгаарлах, маргааныг таслан зогсоохын тулд буруугаар ашигладаг. Үүнийг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр олон улсын шүүхүүд Засгийн газруудад хүний эрхийг хязгаарлахдаа эрүүгийн шийтгэл хүлээлгэхээс түдгэлзэхийг зөвлөсөн.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага өнгөрсөн онд нэр төр гутаахтай холбоотойгоор 2008 онд хот, хөдөөгийн шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдэд судалгаа хийсэн юм. Баянхонгор аймгийн шүүх судалгаанд оролцохоос татгалзсан болно. Шүүх хурлын материалууд архивт шилжээгүй байсан тул 2009 оны хэрэгт судалгаа хийж амжаагүй билээ.

Манай байгууллагын судалгаагаар 2008 онд Улаанбаатар хот, 20 аймгийн шүүхээр нэр төр, алдар хүнд, гүтгэлэгтэй холбоотой нийт 46 хэрэг шийдвэрлэгджээ.

### ***Эрүүгийн хэрэг***

2008 онд 6 хүний нэхэмжлэлтэй эрүүгийн таван хэрэг Улаанбаатар хотод шийдвэрлэгдсэн байна. Зарга мэдүүлэгчдийн 62.5% нь улс төрч, төрийн албан тушаалтан, албан хаагч байжээ. Эрүүгийн гурван хэрэгт ХМХ, сэтгүүлч ялагдаж, хоёрт нь ялжээ. Шүүхээс сэтгүүлчийг баричвлах, хорих ял ногдуулаагүй боловч оногдуулсан торгуулийн дээд хэмжээ нь 5 508 000 төгрөг байв. Сард дунджаар 200 мянган төгрөг хүрэхтэй үгүйтэй цалин авдаг сэтгүүлчийн хувьд энэ бол маш их мөнгө юм. Учир нь, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар редакци нийтлэл, нэвтрүүлгийнхээ төлөө хариуцлага хүлээдэг боловч сэтгүүлчид редакцитайгаа хийсэн гэрээний дагуу ихэнх тохиолдолд хариуцлагыг өөрөө хүлээдэг. ХМХ шүүхийн шийдвэрээр торгууль төлсөн ч тухайн сэтгүүлчийн цалингаас суутгадаг.

### ***Иргэний хэрэг***

Харин нийслэл, хөдөөд нэр төр гутаахтай холбоотой иргэний хэрэг 39 шийдвэрлэгдсэнээс 21 нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчтэй холбоотой байжээ. Иргэний хэргийн нэхэмжлэгчийн 65% нь улс төрч, эрх баригч, төрийн албан тушаалтан байв.

Шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний нийт хэргийн 71.4% -д ХМХ, сэтгүүлч ялагдаж, 9.5%-д ялсан бол үлдсэнд нь нэхэмжлэгч, хариуцагч хоёр эвлэрчээ.

Нэхэмжлэлийн дээд хэмжээ 200 сая төгрөг, шүүхээс оногдуулсан торгуулийн дээд хэмжээ нэг сая, доод хэмжээ 500 мянган төгрөг байлаа.

Сэтгүүлчдийн дунд хийсэн судалгаагаар тэднийг сүрдүүлэгсдийн тал хувь нь Иргэний, Эрүүгийн хуулиар далайлгасан нь улс төрч, эрх баригчид Иргэний болон Эрүүгийн хуулийн нэр төр гутаахтай холбоотой зүйл заалтыг цензур болгон ашигладаг нь нотлогдож буй юм.

“Нэр төр гутаах ба цензур” судалгаанд хамрагдсан сэтгүүлчдийн 14 хувь нь тэдний хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн гэсэн бөгөөд дээд тал нь 100 мянган төгрөгийн торгууль төлсөн байна.



Завхан аймгийн “Завхан” сонины 2009 оны 02-р сарын 10-ны өдрийн №04/267/ дугаарт бид иргэдээс ирсэн нэргүй захидал нийтэлсэн юм. Энэ захидалд “Яруу сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, тамгын газрын нэр бүхий албан тушаалтнуудын ажил хэрхэн ямар замаар явагддаг, суманд сонгууль хэрхэн явагдаж, төрийн хөрөнгө мөнгө хаашаа урсдаг” тухай тодорхой бичсэн байсан юм. Иргэдийн гомдсондоо хэрэглэсэн бүдүүлэг үг хэллэг, доромжилсон утгатай хэсгийг бид редакторлан хэвлүүлсэн юм.

Сонины маань энэ дугаар гарсан даруйд 700 захиалагчаас гадна иргэд олноор худалдан авч уншин, үнэнийг ил тод нийтэлсэнд талархаж байсан.

Гэвч “худал зүйлийг үнэн болгож бичлээ” хэмээн нийтлэлд дурдагдсан сумын Засаг дарга, түүнийг тойрон хүрээлэгчид шүүхэд гомдол гаргаж, нэр төрөө сэргээлгэхийг шаардан 9 сая төгрөг нэхэмжилсэн юм.

Аймгийн Анхан шатны шүүх, Давж заалдах шатны шүүх хуралд бид ялагдсан Шүүхүүдийн шийдвэр бидэнд хүнд байлаа. Ямар нэгэн ивээн тэтгэгчгүйгээр хөдөөгийн жижиг зах зээл дээр оршин тогтнож, өөрсдийн хүчээр сониноо хэвлүүлж борлуулна гэдэг хэцүү. Гэтэл энэ их мөнгийг бид хэрхэн барагдуулах билээ. Сонин дампуурна гэсэн үг. Гэхдээ бууж өгөөгүй.

Далан жилийн түүхтэй “Туяа” сонины суурин дээр байгуулагдсан орон нутгийн цорын ганц сонин нь манайх. Энэ утгаараа Завханчууддаа, уншигчиддаа үнэн бодитой мэдээллийг цаг алдалгүй түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэхийг зорьдог. Бид хаагдвал Завханчуудын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хумигдах болно шүү дээ.

Үнэнийг нийтэлснийхээ төлөө манай сонин ийн хариуцлага хүлээх болсон юм. Бид төр захиргаа, улс төрийн нам, эвсэлд хандаагүй. Харин тэмцэж байсан.

Тэгээд “Глоб Интернэшнл” ТББ-д хандаж, хуулийн зөвлөгөө, өмгөөллийн туслалцаа авсаны хүчээр бид Улсын Дээд шүүхэд даван заалдсан. Улсын Дээд Шүүх хэргийг анхан шатны шүүхэд буцаах шийдвэр гарсан юм.

**“Завхан” сонины эрхлэгч Б.Мягмарсүрэн**

**ХОЁР. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ**

2009 онд хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах чиглэлээр эрх зүйн хүрээнд нааштай өөрчлөлт гараагүй.

2009 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн алба Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн хувилбарын төсөл боловсруулж, хэвлэл мэдээллийнхэн, сэтгүүлч, иргэдээр өргөн хүрээтэй хэлэлцүүлсэн боловч ажил хэрэг болоогүй байна. Хуулийн шинэчилсэн хувилбарт ХМХ-ийн хараат бус байдлыг улам баталгаажуулах, өмчлөлийг ил тод болгох, хэвлэлийн зөвлөлийн эрх зүйн үндсийг тавих зэрэг зарчмын зарим өөрчлөлт тусгагдсан байв.

Сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах тухай хууль Монголд байхгүй. Мөн хэвлэл мэдээллийн өмчлөл, бөөгнөрөл, өргөн нэвтрүүлгийн хэрэгслийн тухай зэрэг чухал хууль байхгүй болно.

УИХ-аас 2009 оны 06-р сарын 25-ны өдөр Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан нь Хэвлэл мэдээллийн эрх зүйн салбарт гарсан цорын ганц өөрчлөлт байв. Энэ хуулийн 11.6 болон 14.1 зүйлээр шар айраг, дарс сурталчлахыг зөвшөөрсөн болно. Хууль тогтоогчид үүнийгээ эдийн засгийн хямралын үед ХМХ-ийг эдийн засгийн хувьд дэмжих, архины зохистой хэрэглээг төлөвшүүлэх гэх мэтээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр тайлбарлан сурталчилсан, ХМХ-ийнхэн ч нааштай хүлээн авсан байна. Харин эрүүл мэндийнхэн, иргэний нийгмийнхэн үүнд сөрөг хандлагатай байгаа юм. Гэхдээ хүчтэй шүүмжилж, эсэргүүцээгүй. Учир нь УИХ хуулийн нэмэлт өөрчлөлтийг маш түргэн хугацаанд баталсан тул ийм боломж ч гараагүй.

Иргэдийн мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийн төсөл анх удаа 2004 онд УИХ-ын хэлэлцэх асуудлын дэгд орсон боловч өнөө хэр батлагдаагүй байна. 2009 оны 1-р сард “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага, Нээлттэй Нийгэм Форумын удирдлага хууль санаачлагч УИХ-ын зарим гишүүнтэй уулзаж, өмнө нь 2007 онд УИХ-д өргөн барьсан хуулийн төслийг сайжруулахаар тохиролцон, “Мэдээлэл авах эрхийн тухай хууль” хэмээх шинэ хувилбар боловсруулсан билээ. 2009 оны 4-р сарын 28-нд УИХ-ын ажлын хэсэг байгуулагдсан боловч өнөө хэр хууль хэлэлцэгдээгүй байна.

Тагнуулын Ерөнхий газраас Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн хувилбар боловсруулсан боловч өнөө хэр УИХ-д өргөн бариагүй байна.

Өнөөгийн хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улс иргэдийнхээ үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэлтэй байх, хэвлэн нийтлэх эрхийг баталгаажуулсан.

Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ хэмээн заасан юм.

16.16. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно.

16.17. Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал,

нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.

Монгол Улс НҮБ-ын гишүүний хувьд Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг хүлээн зөвшөөрсөн. 1974 онд Иргэний болон Улс Төрийн Эрхийн Олон Улсын Пактад нэгдэн орсон. Иймд Монгол Улс дээрх хоёр бичиг баримтын 19-р зүйлд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг олон улсын эрх зүйн дагуу хамгаалах үүрэгтэй. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд зааснаар дээрх зүйл заалт дотоодын хууль адил хүчин төгөлдөр байна.

1998 оны 8 дугаар сарын 28-ны өдөр УИХ-аас Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль баталсан юм. Хуулийн 2-р зүйлээр хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглосон юм. Мөн 3 дугаар зүйлээр “төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тавихыг хориглож, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ” гэж заасан ба 4-р зүйлээр “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно” гэжээ.

УИХ-аас 2005 оны 1-р сарын 27-нд ОНРТ-ийн тухай хууль баталсан нь хэвлэлийн эрх чөлөөг хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн чухал ач холбогдол бүхий алхам байлаа. Хууль 2005 оны 7-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болон төрийн мэдлийн байсан Монголын Үндэсний Радио, Телевизийн Хэрэг эрхлэх газар татан буугдсан билээ. Түүний оронд Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевиз (МҮОНРТ) байгуулагдан 2006 оны 2-р сарын 8-ны өдөр Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамны Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.

2002 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 139-р зүйлээр сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийх нь гэмт хэрэг гэж үзсэн юм.

Гэсэн хэдий ч Монголд үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн эрх, эрх чөлөөг хязгаарласан олон олон үйлчилж байна.

Монгол Улсад төрийн нууцыг Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар хамгаалдаг. Төрийн нууцын тухай хууль 1995 онд батлагдаж, хамгийн сүүлд 2004 оны 1-р сарын 2-нд нэмэлт өөрчлөлт оруулсан. Төрийн нууцын тухай хуульд: “Төрийн нууц” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, тус улсын гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажилтай холбоотой бөгөөд задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийг томъёолол, дүрс зураг, дохио тэмдэг, техник-технологийн шийдэл болон үйл ажиллагааны хэлбэрээр өөртөө агуулж байгаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг.

Хуулийн 11-р зүйлд зааснаар “Төрийн нууцыг задруулснаас Монгол Улсын ашиг сонирхол, аюулгүй байдалд учирч болох хор уршгийн хэмжээнээс хамааран төрийн нууцын зэрэглэлийг тогтооно” гэсэн бөгөөд төрийн нууц нь онц чухал-маш нууц, маш нууц, нууц гэсэн гурван зэрэглэлтэй байна.

Төрийн нууцын тухай хуулиар төрийн нууцыг үндсэн 5 төрөлд ангилдаг. Мөн Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар 59-н зүйлийн мэдээллийг, тухайлбал үндэсний аюулгүй байдлын хүрээнд 19, батлан хамгаалах хүрээнд 14, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, технологийн хүрээнд 5, тагнуул, сөрөх

тагнуул, гүйцэтгэх ажлын хүрээнд 15, бусад хүрээнд 6 зүйлийн мэдээллийг нууцлахаар тогтоожээ. Нийт 59 зүйлээр тогтоосон мэдээллийн 69.5 хувийг 40-60 жилээр, эсвэл байнга нууцалсан байна.

Нууцалсан зэрэглэлээр үзвэл онц чухал-маш нууц мэдээлэл 6, маш нууц мэдээлэл 24, нууц мэдээлэл 7 байна. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулинд шууд зааж өгөөгүй, нууцалсан зэрэглэлээр гэж ангилсан 25 мэдээлэл байгаа юм.

2004 оны 4-р сарын 23-нд нэмэлт оруулсан Төрийн нууцын жагсаалтын хуульд

“Терроризмтой тэмцэх ажиллагаатай холбогдох мэдээ, баримт бичгийг бүхэлд нь нууцалсан зэрэглэлээр, байнга”-ын хугацаагаар нууцлах ажээ.

Эрүүгийн хуулийн 87.1 дүгээр зүйлд төрийн нууц задруулах гэмт хэргийг зааж өгсөн байдаг. Үүнд “Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг итгэмжлэгдэн хариуцсан буюу албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсан нь эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжгүй бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”, 87.2 дугаар зүйлд “Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан байдаг.

1995 оны 5 дугаар сарын 16-ны өдөр баталсан Байгууллагын нууцын тухай хууль нь нууцын дэглэмийг байгууллагад хамруулсан. Үүнд байгууллагын нууц нь тухайн байгууллагын хамгаалалтад байна. Байгууллага нь нууцаа хамгаалах журмыг өөрөө тогтоож мөрдөнө гэж заасан /5.1/ Энэ хатуу заалтыг 6 дугаар зүйлээр зөөлрүүлэх оролдлого хийж нууцлахыг хориглох мэдээллийн жагсаалтыг баталсан. Үүнд тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл бол, мөн тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээллийг нууцлахыг хоригложээ. Мөн гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээллийг байгууллага нууцалж болохгүй ажээ.

Эрүүгийн хуулийн 164-р зүйлээр санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагааны нууцыг хууль бусаар олж авах, задруулбал торгохоос эхлэн гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэхээр заасан. Энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол дээд тал нь гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх юм байна.

Иргэний нэр төр, алдар хүнд ажил хэргийн нэр хүндийг Иргэний болон Эрүүгийн хуулиар хамгаалдаг.

2002 оны 9-р сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн 110, 111-р зүйлээр доромжлол, гүтгэлгийг гэмт хэрэг гэж үздэг. Энэ зүйл заалтаар нэгээс зургаан сар баривчлах ял ногдуулж болно.

Эрүүгийн хуулийн эдгээр зүйлд Улсын Дээд шүүхээс 2007 оны 10-р сарын 29-нд тайлбар гаргаж, нэр төр, алдар хүнд, доромжлох, гутаах зорилго, худал гүжирдлэг, олон нийт, урьд ял шийтгүүлсэн гэх мэт дээрх зүйлд дурдагдсан нэр томъёог тайлбарлажээ.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага энэ тайлбарыг дэвшилттэй гэж үзэхгүй байгаа юм. Манай хуульч энэ тайлбарт дүгнэлт хийж, нэр төр, алдар хүнд гэсэн ойлголтыг олон улсын жишигт тохирохгүй, гүтгэх, доромжлох

хэргүүдийг хэлбэрийн бүрэлдхүүнтэй хэрэг гэдэг нь тийм ч зөв тайлбар биш, ялангуяа “гүтгэх гэмт хэрэг дээр хэлбэрийн бүрэлдхүүнтэй гэж тайлбарласан нь гүтгэсэн гэж үзэж байгаа мэдээлэл үнэн бодит байдалд нийцэхгүй, худлаа мэдээлэл юм гэдэг нь тогтоогдвол шууд л гэмт хэрэг үйлдсэн байна гэж ойлгохоор болсон байна” гэжээ.

2002 оны Иргэний хуулийн 21 дүгээр зүйлээр иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалсан байна.

Эрүүгийн хуулиар сэтгүүлчдийг шийтгэж болзошгүй зарим заалтыг энд дурдав.

Эрүүгийн хуулийн 136.1-д зааснаар “Хуулиар хамгаалагдсан хувь хүний нууцыг албаны болон мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа мэдсэн этгээд задруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ”.

Мөн хуулиар садар самууныг сурталчилсан (123-р зүйл), иргэний захидал харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчсөн (135-р зүйл), шашны харгис үзэл номлолыг санаатай сурталчилсан буюу тараасан бол (144.1-р зүйл), Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хэргийн мэдээ баримтыг задруулсан бол (257.1-р зүйл) торгохоос нэгээс гурван сарын хугацаагаар баривчлах хүртэл ял шийтгэх ажээ.

Мөн олон нийтийн дунд дайн явуулахыг сурталчилсан, дайнд уриалсан бол (298.1-р зүйл) нэгээс гурван сар баривчлах ба энэ хэргийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах замаар буюу төрийн албан хаагч үйлдсэн бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Энэ хуульд тайлбарласнаар “Төрийн албан хаагч” гэдэгт шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гааль, татварын албаны байцаагч, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч нарыг хамруулан ойлгоно.

\*\* \*\* \*

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний баталгаа нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжин хэрэгжиж, хэвлэлийн эрх чөлөөг бодитой болгодог. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангахын тулд хэвлэл мэдээлэл төрийн хяналтаас ангид байх ёстой. Энэ нь хэвлэл мэдээллийн “хоточ нохой” байх үүргээ биелүүлэх, иргэд олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн хэрэг явдлын тухай үзэл бодлоо солилцох боломж олгодог.

Харамсалтай нь, Монголд хэвлэлийн эрх чөлөө хязгаарлагдмал, сэтгүүлчид нийгмийн жинхэнэ “хоточ нохой” байх үүргээ биелүүлэх орчин боловсронгуй бус байна.

Монгол улсад хараат бус хэвлэл мэдээлэл улс төр, эдийн засаг, эрх зүйн хүрээний олон сорилттой тулгарч байна.

Монгол Улс өнөө хэр хэвлэлийн хагас эрх чөлөөтэй оронд тооцогдсон хэвээр байгаа билээ.